3. Усан хил болж байгаа голын үндсэн гольдролын өөрчлөлтийн талаар судалгааг хөтөлж баримтжуулан газрын гадаргуу дээрх усан хилийн эргийг бетондож, гольдрол өөрчлөгдөхгүй байх арга хэмжээг авах.

4. Хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг хилийн зөрчлийн илрүүлэлт, хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулсан талаар хилийн застав, отряд нэгжүүдийн ажил дүгнэх журамд тусган оруулах

5. Хилийн зөрчлөөс урьдчилан сэргийлсэн ажлыг хилийн зөрчил илрүүлсэнтэй адил хэмжээнд тооцож үнэлж байх хэрэгтэй бөгөөд ингэснээр хил хамгаалах байгууллагын үндсэн үүрэг, "Төрөөс хилийн талаар баримтлах бодлого”-ын хэрэгжилт нь улам боловсронгуй болно гэж үзэж байна.

***Н.Очирдорж*** *-Хууль сахиулах удирдлагын академийн*
*821 дүгээр дамжаан суралцагч дэд хурандаа*

## УЛСЫН ХИЛ ХАМГААЛАХ ОПЕРАТИВ УРЛАГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй:*** *Улсын хил хамгаалалтын урлагийг хөгжүүлэх асуудал нь нийгмийн хөгжил, эрхзүйн орчны шаардлага бөгөөд цаад утгаараа бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэх үндэс хил хамгаалах байгууллагын удирдлагын хэмжээнд анхаарах асуудал болоод байна.*

***Түлхүүр үг:*** *Улсын хил хамгаалалт, хил хамгаалах урлаг. хил хамгаалах оператив урлаг.*

Хил судлалын шинжлэх ухаан, хил хамгаалах урлагийн онолын салшгүй, бүрэлдэхүүн хэсэг нь “Хилийн цэргийн оперативын урлаг" юм.

***Хилийн цэргийн оперативын урлаг гэдэг нь*** улсын хил дээр буюу хилийн орон зайд Монгол Улсын улс төр, эдийн засаг, цэргийн ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор хилийн цэргийн оперативын бүлгүүдийн (хилийн төлөөлөгчийн газрын) ажиллагааг бэлтгэх, явуулахтай холбогдсон онол, практикийн цогцолбор мөн[1].

Шинэчилэн батлагдсан “Хилийн тухай хууль”-д

1. Хилийн нөхцөл байдал, байгаль, газар зүй, цаг агаарын онцлогийг харгалзан улсын хил хамгаалалтыг ялгавартайгаар зохион байгуулахыг бүсчилсэн хил хамгаалалт гэнэ.

[1] *Н.Наранжамц.* Хилийн операци. - УБ., 1998. 29 дэх тал.

2. Бүсчилсэн хил хамгаалалттай уялдуулан хилчний хилийн нэмэгдэл. цалин хангамж, материал хэрэгслийн хангалтын норм, хэмжээг Засгийн газар тогтооно.

3. Улсын хил хамгаалалтыг бүсчилсэн байдлаар зохион байгуулах, түүний арга хэлбэр. хангалт үйлчилгээтэй холбоотой журам, зааврыг улсын хил хамгаалах байгууллагын дарга батална гэж заажээ.

Энэ нь бидэнд хил хамгаалалтын урлагийг хөгжүүлэх шаардлага бий болсныг харуулж байна. Бүсчилсэн хил хамгаалалтад шилжинэ гэдэг нь хил хамгаалах байгууллагын хил хамгаалалтын оператив урлагийн хөгжилд дүн шинжилгээ хийж, боловсронгуй болгох арга замыг судлаж гаргах цаг болсныг илтгэж байна.

Эндээс “хил хамгаалах оператив урлаг" гэж юу вэ? гэсэн асуулт урган гарч ирж байна. Хил судлалаар мэргэшсэн эрдэмтэд дараах байдлаар тодорхойлон гаргажээ.

Хилийн цэргийн оператив урлаг нь улсын хил хамгаалалтын урлагийн салшгүй, чухал хэсэг болохын хувьд тэрээр хилийн стратеги, хилийн цэргийн тактикийн завсарт холбогч үүрэг хүлээж стратегийн зорилтыг хэрэгжүүлэх, тактикийг төгөлдөржүүлэх, хил хамгаалалтын урлагийн онол, практикийн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэдэг байна.

Хилийн цэргийн оперативын урлаг нь онол, практикийн хоёр талт үйл ажиллагаа бөгөөд онолын хэсэгт хилийн цэргийн оперативын бүлгүүдээс явуулах хил хамгаалах үйл ажиллагааг шинжлэх ухааны үзэл баримтлалд үндэслэн боловсруулах, гарах үр дүнг дээшлүүлэх зорилтыг хэрэгжүүлдэг бол практик хэсэгт нь хилийн цэргийн оператив бодит үйл ажиллагаа, энэ үеийн удирдлага зохион байгуулалтын болон цэргийг удирдах, бүх талаар хангах асуудал багтана.

Хилийн цэргийн оператив урлаг нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал. төрийн цэргийн болон хилийн талаар баримтлах бодлого, бусад хууль тогтоомж. шинжлэх ухааны үзэл баримтлалыг үндэслэн дараах *үүргийг* хэрэгжүүлнэ:

- хилийн цэргийн оператив урлагийн талаарх шинжлэх ухааны үндэслэлийг боловсруулж, практикт хэрэглэх арга замыг тодорхойлох;
- хилийн цэргийн оперативын бүлгүүдээс улсын хил хамгаалалтыг зохион байгуулж явуулах ажиллагааны арга, хэлбэрийг тодорхойлох, тэдгээрийн үндэслэл, шаардлагыг бататгах цаашид төгөлдөржүүлэх чиглэлийг тогтоох;

- хилийн цэргийн оперативын бүлгүүдээс улсын хил хамгаалалтыг зохион байгуулах ажиллагаанд цэргийн болон төрийн байгууллагуудын янз бүрийн хүч хэрэгслийн ашиглах арга ажиллагааг тодорхойлох;
- оперативын масштабт явуулж буй ажиллагааны үеийн харилцан ажиллагааг хангах бүх төрлийн хангалтуудыг зохион байгуулах асуудлыг тодорхойлох;
- улсын хил дээр болон хилийн орон зайд гарч болох тагнуул, хорлон сүйтгэх ажиллагааны шинж байдлыг судалж. эсэргүүцэх арга механизмыг тогтоох төгөлдөржүүлэх;
- операц явуулах чиглэл, масштаб дахь анги, салбаруудын алба байлдааны бэлэн байдлыг хангахтай холбогдох цогц асуудлыг шийдвэрлэх;
- хилийн цэргийн оперативын бүлэг түүний бүтэц, зохион байгуулалт, орон тоо, зэвсэглэлд тавигдах шаардлагыг тодорхойлох:
- батлан хамгаалах нэгж, ерөнхий зориулалтын цэрэг, аюулаас хамгаалах байгууллага, цагдаа, цэргийн бусад байгууллагатай улсын хил хамгаалалтаар тавигдсан үүргийг хэрэгжүүлэх явцад харилцан ажиллагааны үндсийг боловсруулах;
- хилийн стратегийн операцийг зохион байгуулах, явуулах үндсэн бодомж, төлөвлөгөөнд үндэслэн хилийн цэргийн оператив бүлгийн гүйцэтгэх үүргийг тодорхойлох. ажиллагааг зохион байгуулах;
- Операц явуулах чиглэл, масштаб мэдээ мэдээллийн шуурхай байдлыг хангах, мэдээллийн цогц систем бий болгох, ашиглах асуудлыг тодорхойлох.

Хилийн цэргийн оперативын бүлгээс эрхлэн явуулах ажиллагааны онолын асуудлыг хилийн цэргийн оперативын урлаг судалж, практик үйл ажиллагаанд чиглүүлж байдаг тухай нэгэнт дурдсан билээ.

Хилийн цэргийн оперативийн урлаг нь өөрийн гэсэн үйл ажиллагааны төрөл, хэлбэр, аргатай байдаг болно.

Үйл ажиллагааны төрөл гэдэг нь хилийн стратегийн болон оператив-стратегийн зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор оперативын масштабт төрөл бүрийн хүч хэрэгслийг зохион байгуулалттайгаар хэрэглэх явдал юм. Эдгээрт цэргийн, алба-байлдааны, тагнуул-байлдааны, цэрэг-техникийн гэсэн төрлүүдийг хэлж болно.

Хил хамгаалалтын оперативын бүлгүүдээс явуулах ажиллагааны үндсэн *хэлбэр* гэдгийг хилийн цэргийн гүйцэтгэж буй үүрэг зорилго, ажиллагааны шинж чанар, тухайн чиглэл дэх хилийн цэргийн оператив

бүлгүүдийн боломж, үйл ажиллагааны масштабт нийцүүлэн хүч хэрэгслийг зохион байгуулалттайгаар хэрэглэх явдал гэж ойлгож болно[1].

Хилийн цэргийн оперативын бүлгүүдийн ажиллагааны үндсэн хэлбэр нь:

- улсын хил хамгаалалт;
- хилийн оперативын операци;
- хилийн тусгай операци;
- оперативын масштабт цэргийг шилжүүлэн бүлэглэх зэргээс бүрдэх бөгөөд зарим тохиолдолд хилийн орон зайд байлдааны цагийн байдал үүссэн. хилийн мөргөлдөөн, зэвсэгт будлиан үргэлжлэн гарсаар байгаа чиглэлд хэсэгчилсэн алба-байлдааны ажиллагаа гэсэн хэлбэрийг авч хэрэгжүүлж болно.

Хилийн цэргийн оперативын урлагийн цаашдын хөгжилд төрөөс хилийн талаар баримтлах бодлого, Монгол Улсын гадаад, дотоод нөхцөл байдал, улсын хилийн оперативын цагийн байдлын өрнөлт, ХХЕГ-ын гүйцэтгэх үүрэг, бүтэц, зохион байгуулалтад гарч болох өөрчлөлт, хил залгаа улсуудын улсын хилийн талаар баримтлах бодлогын практик хэрэгжилт, хил судлалын шинжлэх ухаан болон хил хамгаалалтын урлагийн онолын бусад хүчин зүйл нөлөөлнө.

Хил хамгаалах оператив урлагыг хөгжүүлсэнээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

1. Манай орны хувьд юуны өмнө хил судлалын шинжлэх ухаан, хил хамгаалалтын урлагийг жинхэнэ утгаар нь гаргаж тавих, үүний тулд хилийн цэрэгт ажиллаж байгаа болон ажиллаж байсан эрдэмтэд, хил хамгаалалтын бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үүрэг бүхий удирдлагын офицеруудаас бүрдсэн тусгай бүлгийг ХХЕГ-аас санаачлан байгуулах;
2. Хил хамгаалалтаар тавигдсан үүрэг даалгаврыг хэрэгжүүлэхээр анги, салбаруудын бэлэн байдал, сургалтыг эрс дээшлүүлэх, хилийн цэргийн оперативын бүлгүүдийн хамгийн боломжтой бүтэц, зохион байгуулалт, орон тоог бий болгох;
3. Хилийн операциудыг чухал чиглэлүүдэд үе үе явуулж байх, үүний үндсэн дээр хилийн цэргийн оперативын бүлэг, хилийн отряд, тусгай ангиудын бие даасан болон бусад байгууллагуудтай хамтарсан ажиллагаануудын туршлагыг нэгтгэх.

[1] *Ш.Арвай, А.Муратхан, Д.Нямдорж, Н.Наранжамц.* Улсын хил судлал: онол, практикийн зарим асуудал. - УБ., 2016. 93 дахь тал.

Ингэснээр хил судлалын шинжлэх ухаан, хил хамгаалалтын оператив, тактикийн урлагт дэвшил гарч хил хамгаалалтын нэгдмэл тогтолцоо баталгаажна.

Бүсчилсэн хил хамгаалалт нь өнөөгийн хил хамгаалалтын тактикийн түвшиний хил хамгаалах тогтолцооноос оперативын түвшиний буюу хилийн цэргийн оперативын урлагийг хөгжүүлсэн, хил хамгаалах байгууллагын байгуулалтыг төгөлдөржүүлж, багтаамжийг нэмэгдүүлсэн. их хэмжээний газар нутаг бүхий улсуудын жишигт ойртсон хил хамгаалалтын байгууламжийг сайжруулсан, цар хүрээ, ач холбогдол бүхий арга хэмжээ болно гэдэгт эргэлзэхгүй байна.

***Б.Баянмөнх*** *- Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, хошууч*

## ОЙ ТАЙГЫН БҮСИЙН ХИЛИЙН ОТРЯДЫН ШУУРХАЙ БҮЛГИЙН СУРГАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ

***Хураангуй:*** *Хилчдийн сургалт бэлтгэлийг чанаржуулж алба, үйл ажиллагаа явуулах таатай орчинг бүрдүүлснээр хилчдийн сэтгэл зүйд эерэгээр нөлөөлж, улсын хил хамгаалалт чанартай, хурдан шуурхай, уян хатан, тасралтгүй явагдах боломжтойг харуулахыг зорилоо.*

***Түлхүүр*** *үгс: Хилийн отрядын шуурхай бүлгийн үйл ажиллагаа, сургалт зохион байгуулалт.*

Дэлхий дахинд мэдлэгт суурилсан хөгжлийн чиг хандлагыг эргэлт буцалтгүй сонгон авсан өнөө үед хил хамгаалах байгууллагын хэмжээнд сургалтын үйл ажиллагаа 5 жилийн хугацаатай хэрэгжиж байна. “Сургалт бэлтгэл” хөтөлбөрийн хүрээнд эдгээр сургалтын үр дүнг баталгаажуулан бэхжүүлэх, цаашид хөгжүүлэн боловсронгуй болгох шаардлагатай байгаа нь хилийн отрядын шуурхай бүлгийн эрэлт хэрэгцээ, албаны шаардлагад нийцсэн сургалтыг явуулах стандарт төлөвлөгөө, хөтөлбөр, бүсийн хил хамгаалалтын онцлогт тохирсон сургалтын хэлбэрийг бий болгох зэрэг асуудал үгүйлэгдэж байна.

Манай орны хувьд түүнтэй тэмцэх талаар онол, арга зүйн түвшинд судалгаа явагдаж байгаа бөгөөд “терроризмтэй тэмцэх тухай” хуулийг 2004 онд батлан гарган, эрх зүйн хувьд баталгаажуулсан. Монгол улсын ерөнхийлөгч, зэвсэгт хүчний ерөнхий командлагч Н.Энхбаяр 2005 оны 7 дугаар сард ХХЕГ-ын ажил байдалтай танилцахдаа хэлсэн үгэндээ “терроризмтэй тэмцэх тухай хууль"-ийг УИХ өнгөрсөн онд батлан гаргаснаар олон улсын терроризмын аюулаас сэрэмжлэх түүнээс ард иргэд